БИЗКОН АУДИТ

АУДИТЫН ТАЙЛАН

"МББСБХолбоо" ГҮТББ
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон
Санхүүгийн Тайлан
Хараат Бус Аудиторын Тайлангийн Хамт

УЛААНБААТАР
2022 он

БИЗКОН АУДИТ ХХК
АУДИТ, БАТАЛГААЖУУЛАЛТ, БИЗНЕСИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, АУТСОРСИНГ, СУРГАЛТ

2022 он 03 сар 04 өдөр Дугаар СТА-10/22 Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"МБЬСБХолбоо" ГҮТББ-ийн удирдлагад

Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

Дүгнэлт

Бид "2021 оны 12-р сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодолгын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "МБЬСБХолбоо" ГҮТББ-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний өгсөн удирдлагын зөвлөмж тайланд тусгагдсан асуудлуудын санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг нөлөөллийг эс тооцвол "МБЬСБХолбоо" ГҮТББ-ийн 2021 оны 12-р сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм-ийг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба НБЁЗОУС3-ийн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Монгол Улс, Улаанбаатар-210646, Чингэлтэй дүүрэг, Найман шарга, "Бизкон Аудит" ХХК-н байр, ш/х 46-845,
[УТАС/ФАКС: 976-70119107, 976-11-312773, 976-99119107, 976-96969607, 976-95959107]
[Э-шуудан: info@bizcon.mn. Вэб: www.bizcon.mn]

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС –ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандалгыг баримтлан ажилладаг.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үзэж аудиторын тайландаа тодорхойлдог.

ХҮНДЭТГЭСЭН:

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Л. ОТГОНБАЯР

БИЗКОН АУДИТ ХХК
BIZCON AUDIT LLC
УЛААНБААТАР ХОТ
ТТГ4917 № 2704404

"МБББСБХолбоо" ГҮТББ
АУДИТЛАГДСАН БАЛАНС
2021 оны 12 сарын 31

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө:		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7,930,927.96	927,389.40
Дансны авлага	3,600,000.00	
Татвар, НДШ-ийн авлага		
Бусад авлага	51,782,521.47	56,620,327.01
Бараа материал	7,146,971.42	8,706,881.42
Бусад эргэлтийн хөрөнгө хангамж		
Урьдчилж төлсөн тооцоо	1,850,000.00	1,850,000.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	**72,310,420.85**	**68,104,597.83**
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	9,949,313.99	9,489,607.43
Биет бус хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
Дуусаагүй барилга		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	**9,949,313.99**	**9,489,607.43**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	82,259,734.84	77,594,205.26
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өглөг		
Дансны өглөг	2,872,190.72	
Цалингийн өглөг		
Татварын өглөг	2,114,000.00	7,910,287.21
НДШ-ийн өглөг		1,453,636.34
Богино хугацаат зээл		
Хүүгийн өглөг	253,046.98	
Бусад богино хугацаат өр төлбөр		
Урьдчилж орсон орлого	3,600,000.00	
Богино хугацаат өглөгийн дүн	**8,839,237.70**	**9,363,923.55**
Урт хугацаат өглөг		
Урт хугацаат зээл		
Бусад урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өглөгийн дүн	-	-
Нийт өр төлбөрийн дүн	**8,839,237.70**	**9,363,923.55**
Эзэмшигчийн өмч		
Хувийн өмч		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
Эзний өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг	73,420,497.14	68,230,281.71
Эзэмшигчдийн өмчийн дүн	**73,420,497.14**	**68,230,281.71**
НИЙТ ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР	82,259,734.84	77,594,205.26

ВИЗИОН АУДИТ

"МББСБХолбоо" ГҮТББ
ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
2021 оны 12 сарын 31

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
Гишүүдийн татвар	108,150,000.00	108,700,000.00
Сургалтын төслийн орлого	46,595,009.00	32,307,500.00
Тайлан байршуулсан сайтны орлого		5,720,000.00
Бэлэн хандив, тусламжийн орлого, засгийн газрын буцаалт	9,365,282.42	8,040,000.00
Нэр данс зөрүү орлого	474,128.63	
Итгэлцлийн хүүний орлого	7,154,111.86	7,925,649.91
Банкны хүүний орлого	469,376.25	
Арга хэмжээний орлого		15,250,000.00
Нийт ашиг	172,248,283.26	178,982,052.53
Гишүүнчлэлийн төсөл хэрэгжүүлсний зардал		23,240,390.00
Сургалт хөтөлбөр хэрэгжүүлсний зардал	36,436,450.00	24,397,945.00
Цалингийн зардал	65,877,402.92	75,243,986.46
НДШ-ийн зардал	3,775,866.60	8,604,601.48
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал		29,000.00
Тэтгэмж ба урамшууллын зардал		2,750,000.00
Бичиг хэргийн зардал		1,446,790.00
Шуудан холбооны зардал	5,283,559.95	2,665,569.24
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	9,230,000.00	7,540,900.00
сургалтын зардал		99,000.00
Хангамж материалын зардал		50,000.00
Банкны үйлчилгээний шимтгэлийн зардал	357,370.10	181,406.51
засварын зардал		288,500.00
Элэгдэл, хорогдлын зардал	3,527,399.42	3,609,606.57
Түрээсийн зардал	18,775,760.00	17,003,045.00
Сонин сэтгүүл захиалгын зардал		71,200.00
Цэвэрлэгээ ариутгал, шинжилгээний зардал		60,000.00
Зээлийн хүүгийн зардал	396,309.70	667,924.27
Тээвэр, шатахууны зардал	89,000.00	492,106.00
Хүлээн авалтын зардал	1,729,324.00	3,334,146.00
зар сурталчилгаа пи ар сонин-тв сайт	6,720,000.00	4,665,775.00
Оффисын хангамжийн зардал		1,472,614.00
Засгийн газрын буцалтгүй тусламж	9,365,282.42	
томилолтын зардал	6,023,736.70	
Бусад зардал	4,660,821.45	1,067,547.00
Гадаад валютын ханшийн зөрүүний олз(гарз)		
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз(гарз)		
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз(гарз)		
Татварын өмнөх ашиг	(40,375.10)	(1,038,902.62)
Татварын зардал	1,860,515.99	790,660.07
Цэвэр ашиг	(1,900,891.09)	(1,829,562.69)

ВИЗИОН АУДИТ

"МББСБХолбоо" ГҮТББ
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2021 оны 12 сарын 31

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	-	-		70,059,844.38	70,059,844.38
залруулсан үлдэгдэл					
Тайлангийн хугацааны ашиг (алдагдал)				(1,829,562.69)	(1,829,562.69)
залруулсан үлдэгдэл					
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	-	-		68,230,281.69	68,230,281.69

ВИЗИКОН АУДИТ

"[illegible]БСБХолбоо" ГҮТББ
Мөнгөн гүйлгээний тайлан
2021 оны 12 сарын 31

(Төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	270,015,160.25	176,586,885.30
[illegible]вүүдийн татвараас орсон орлого	111,200,000.00	108,700,000.00
Төсөл хөтөлбөрөөс орсон орлого	45,515,009.00	32,245,000.00
[illegible]диваар хүлээн авсан мөнгө	99,382,000.00	8,040,000.00
[illegible]ний орлогоос орсон	469,376.25	2,297,184.30
Татаас Нэр данс зөрүү буцаалтын орлого		4,254,701.00
[illegible]сад мөнгөн орлого	13,448,775.00	21,050,000.00
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	336,953,703.67	183,590,423.86
Ажилчдад олгосон мөнгө	59,311,669.16	65,930,716.76
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	6,311,890.14	15,379,014.62
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн мөнгө	146,491,220.38	63,213,113.48
Бараа материал худалдан авахад төлсөн	118,997,171.45	9,915,050.00
[illegible]ргалт хөтөлбөрийн зардал		27,094,945.00
Хүүний төлбөрт төлсөн мөнгө		
Татварын байгууллагад төлсөн мөнгө	5,841,752.54	2,057,584.00
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө		
Бусад мөнгөн зарлага		
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(66,938,543.42)	(7,003,538.56)
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
[illegible]рөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого	-	-
Хүлээн авсан хүүгийн орлого		
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		
Бусдад олгосон зээл,мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
[illegible]рөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		
Бусад мөнгөн зарлага		
[illegible]өрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
[illegible]анхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого	15,000,000.00	
Зээл авсан, өрнийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө	15,000,000.00	
Бусад мөнгөн орлого		
[illegible]анхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага	40,000,000.00	
Зээл төлсөн мөнгө	40,000,000.00	
Бусад мөнгөн зарлага		
Валютийн ханшийн зөрүү	3,717.48	
[illegible]анхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(25,003,717.48)	
4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(41,934,825.94)	(7,003,537.66)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	49,865,753.00	7,930,927.06
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,930,927.06	927,389.40

Аудитор Б.Наранбат

Аудиторын туслах Б.Дэлгэрмаа

Хүлээн зөвшөөрсөн

ВИЗИОН АУДИТ

1. БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1	Байгууллагын нэр:	“МБЬСБХОЛБОО” ГҮТББ
1.2	Улсын бүртгэлийн дугаар:	9071032018
1.3	Регистрын дугаар:	1024949
1.4	Үүсгэн байгуулсан баримт бичиг:	Дүрэм
1.5	Үйл ажиллагааны чиглэл / код/:	4610 Санхүүгийн холбогдолтой мэдээ мэдээллээр хангах, сургалт семинар зохион явуулах, тэдний үйл ажиллагааг сурталчлах, гишүүдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах
1.6	Дүрмийн сан:	0 төгрөг
1.7	УЗ Дарга: Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	З.Алтанзул А.Мөнхбаяр Б.Мөнхтуяа
1.8	Гэрчилгээн дээрх хаяг:	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Төмөрчний гудамж, EXE плаза 2 давхарт,
1.9	Үүсгэн байгуулагдсан огноо:	2002 оны 12 сарын 06
1.10	Улсын бүртгэлд бүртгэгдсэн огноо:	2012 оны 11 сарын 12

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН БАЙДАЛ

Тус компанийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр тайлангуудад хийсэн нэмэлт тодруулгаас бүрдсэн байна.

Компанийн санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу бэлтгэсэн байна.

2.1 Үнэлгээний суурь

Санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчимд үндэслэн аккруэл сууриар бэлтгэсэн.

2.2. Таамаглал, тооцоолол ба үнэлгээний хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол болон үнэлгээ хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлгээ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт болон бүртгэсэн хөрөнгө, өр төлбөр,

ВИЗИОН АУДИТ

орлого, зардлын дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Бодит үр дүн нь эдгээр таамаглал, тооцооллоос ялгаатай байж болно.

Үнэлгээ, тооцоолол түүнийг хийхэд хэрэглэсэн гол чухал таамаглал, төсөөлөл нь байнга хянаж шалгагдаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийн нөлөөллийг тухайн өөрчлөлт хийгдсэн тайлант жил болон ирээдүйн тайлант жилүүдэд тусгадаг.

Санхүүгийн тайланд илэрхийлэгдсэн дүнгүүдэд материаллаг нөлөө үзүүлэхүйц нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын хэрэглээ, тооцооллын тодорхой бус асуудлуудыг доор дурьдсан орлогын тодруулгын хэсэгт багтаасан болно

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

Компани нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ өөрийн компанийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баримталдаг бөгөөд бодлогын баримт бичгийг цаашид сайжруулах шаардлага байгаа болно.

3.1. Мөнгө хөрөнгийн бүртгэлийн бодлого

НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга
СТОУС-7 Санхүүгийнн хэрэглүүр: Тодруулга
НББОУС-32 Санхүгийн хэрэглүүр: Толилуулга

Компанийн касс дахь болон банкны харилцах дансанд байгаа төгрөг, тусгай зориулалт бүхий мөнгөн сан, мөнгөтэй адилтгах бусад зүйлсийг мөнгөн хөрөнгөнд хамааруулна. Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр бүртгэнэ.

3.2. Үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлого

НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга
НББОУС-16 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн зүйлийг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрдөг.

- Хөрөнгөд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөжийг аж ахуйн нэгж хүртэх магадлалтай
- Хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой

Үндсэн хөрөнгийн зүйлийн өртөг дараах зүйлсээс бүрдэнэ.

- Гаалийн татвар, буцаан олгогдохгүй худалдааны татварын дүнг оруулсан худалдааны хөнгөлөлт, буцаалтыг хассаны дараах худалдан авалтын үнэ
- Удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцлийг хангахтай холбоотой аливаа шууд зардлууд
- Тухайн зүйлийг олж эзэмших үед эсвэл түүнийг задлах, зайлуулах болон байрлаж байсан талбайг нь сэргээн засварлахад гарах зардлын анхны тооцоолол.

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсөний дараа үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл ба

ВИЗИОН АУДИТ

хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан өртгөөр үнэлдэг. Бөөн дүнгээр худалдан авсан хөрөнгийн үнийг худалдан авсан хөрөнгийн зах зээлийн үнэ цэнэд үндэслэн хуваарилдаг. Хандиваар авсан хөрөнгийг зах зээлийн үнээр бүртгэнэ. Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэн барьж үндсэн хөрөнгийг барьж дуустал гарсан зээлийн хүүг капиталжуулах бөгөөд түүнээс хойшхи гарсан хүүгийн зардлыг капиталжуулахгүй.

Элэгдэл

Үндсэн хөрөнгийн элэгдэл гэдэг нь хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглахаар тооцсон хугацааны туршид системтэйгээр хуваарилсан хуваарилалт юм. Тайлант үе бүрийн элэгдлийн зардлыг түүний бусад хөрөнгийн дансны үнэд хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрдөг. Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцохдоо "Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай" хуулийн 13 дугаар зүйлийн дагуу тооцно.

3.3. **Орлогын бүртгэлийн бодлого**

НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
СТОУС 21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө
НББОУС 18 Орлого

Орлого гэдэг нь байгууллагын ердийн үйл ажиллагааны явцад тайлант хугацаанд бий болсон бөгөөд өөрийн капитал болгон өмч эзэмшигчдээс оруулсан хөрөнгөөс бусад шалтгаанаар өмчийн өсөлт, өрийн бууралт хэлбэрээр илэрсэн хөрөнгийг бий болгох буюу нэмэгдүүлж буй эдийн засгийн өгөөжийн дотогш урсгал юм.

Орлого хүлээн зөвшөөрөх
Эдийн засгийн ирээдүйн үр ашгийн хэмжигдэж болохуйц өсөлт нь хөрөнгийг нэмэгдүүлэх буюу өр төлбөрийг багасгаж байвал орлого, үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрдөг. Орлогыг хүлээн зөвшөөрснөөр хөрөнгийн өсөлт болон өр төлбөрийн бууралтыг нэг зэрэг хүлээн зөвшөөрнө.

3.4. **Зардлын бүртгэлийн бодлого**

НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга
НББОУС 23 Зээлийн өртөг
НББОУС 37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө

Зардал гэдэг нь хөрөнгийг хасагдуулж, элэгдүүлэх хэлбэрээр тайлант үед гарсан эдийн засгийн үр ашгийн бууралт буюу өмч эзэмшигчдэд хуваарилахаас бусад байдлаар өмчийг багасгах, өр төлбөр нэмэгдэхийг хэлнэ. Зардлын тодорхойлолтонд байгууллагын үндсэн ба үндсэн бус үйл ажиллагааны явцад үүссэн зардлыг хамааруулна.

Зардлыг хүлээн зөвшөөрөх
Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг баримтлан жинхэнэ хэрэгжилтийн зарчмын дагуу бүртгэлээ хөтлөх тул тэдгээрийг мөнгөөр төлөгдсөн эсэхээс үл хамааран

БИЗНЕС АУДИТ

үйл явдал, ажил гүйлгээ хийгдсэн тухайн тайлангийн хугацаанд нь хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгана.

Хөрөнгө багасгах буюу өр төлбөр нэмэгдсэний улмаас эдийн засгийн үр өгөөж буурч, улмаар энэ бууралтыг найдвартай хэмжих боломжтой байвал түүнийг орлого, үр дүнгийн тайланд зардал гэж хүлээн зөвшөөрнө. Энэ зардлыг хүлээн зөвшөөрөхдөө өр төлбөрийн өсөлт буюу хөрөнгийн бууралтыг хамтад нь хүлээн зөвшөөрнө гэсэн үг юм.

Мөн гарсан зардал болон тодорхой зүйлийн өртгийг түүнтэй холбоотой олсон орлогод шууд хамааруулах үндсэн дээр хүлээн зөвшөөрнө. Орлого, зардал зохицох зарчим нь ажил гүйлгээ болон бусад үйл явдлын үр дүнд бий болсон орлого ба зардлыг нэгэн зэрэг хамтад нь хүлээн зөвшөөрөхийг шаарддаг.

Үйл ажиллагааны зардал

Байгууллагын ажилтнуудын цалин, нийгмийн даатгал, материал, хангамж, цахилгаан, халаалт, дулаан, цэвэр ба бохир ус, харилцаа холбоо, шатахуун, бичиг хэрэг, томилолт, элэгдлийн зардлууд зэрэг хамаарна.

Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж

"Нийгмийн даатгалын тухай" хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа компаниуд нь нийгмийн болон эрүүл мэндийн даатгалыг зохих ёсоор төлөх ёстой бөгөөд үг зардлыг гарсан тухайн үед нь орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

1. мөнгөн хөрөнгө

2021 оны 12 сарын 31-ны байдлаар мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дансны дэлгэрэнгүй дараах байдалтай байна.

1.1 Бэлэн мөнгө

Дансны нэр	2021.12.31
Касс төгрөг	38,587.00
Нийт дүн	38,587.00

1.2 Харилцах дансан дахь мөнгө

Дансны нэр	2021.12.31
Харилцах-ам доллар	34,186.56
Харилцах-41	526,911.97
Харилцах төгрөг	327,703.87
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	888,802.40

ВИЗИОН АУДИТ

2. АВЛАГА

2021 оны 12 сарын 31-ны байдлаар авлага дансны үлдэгдэл дараах байдалтай байна.

Дансны нэр	2021.12.31
Итгэлцлийн авлага	50,617,165.96
Итгэлцлийн хүүгийн авлага	6,003,161.05
Бусад авлага	-
Дүн	**56,620,327.01**

3. Хангамж материал

2021 оны 12 сарын 31-ны байдлаар бараа материал дансны үлдэгдэл дараах байдалтай байна.

Дансны нэр	2021.12.31
Бэлэн бүтээгдэхүүн	8,706,881.42
Дүн	**8,706,881.42**

4. Урьдчилж төлсөн тооцоо

2021 оны 12 сарын 31-ны байдлаар бараа материал дансны үлдэгдэл дараах байдалтай байна.

Дансны нэр	2021.12.31
Урьдчилж төлсөн тооцоо	1,850,000.00
Дүн	**1,850,000.00**

5. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Компанийн үндсэн хөрөнгө 2021 оны 12 сарын 31-р доорх байдалтай байна.

Үндсэн Хөрөнгө	
Дансны нэр	2021.12.31
Тээврийн хэрэгсэл	11,421,579.00
Хур.элэгдэл	(3,506,621.59)
Тавилга эд хогшил	10,973,700.00
Хур. элэгдэл	(9,398,749.99)
Дүн	**9,489,607.43**

6. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Дансны нэр	2021.12.31
Татварын өглөг	7,910,287.21
НДШ-ын өглөг	1,453,636.34
Дүн	**9,363,923.55**

ВИЗИОН АУДИТ

7. ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН

Дансны нэр	2021.12.31
Хуримтлагдсан үр дүн	68,230,281.70
Дүн	**68,230,281.70**

8. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

Тайлант жилийн үндсэн үйл ажиллагааны орлого дансны дэлгэрэнгүй дараах байдалтай байна.

Дансны нэр	2021.12.31
Гишүүдийн татварын орлого	108,700,000.00
Сургалт, төслийн орлого	32,307,500.00
Тайлан байршуулсан сайтны орлого	5,720,000.00
Бэлэг, хандив, тусламжийн орлого	8,040,000.00
Итгэлцлийн хүүний орлого	7,925,649.91
Арга хэмжээний орлого	15,250,000.00
Нийт ашиг	**177,943,149.91**

9. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

Тайлант хугацааны Ерөнхий ба Удирдлагын зардал дансны дэлгэрэнгүй дараах байдалтай байна.

Дансны нэр	2021.12.31
Цалингийн зардал	75,243,986.45
НДШ-ийн зардал	8,604,601.48
Албан татвар хураамж	29,000.00
Тэтгэмж ба урамшууллын зардал	2,750,000.00
Бичиг хэргийн зардал	1,446,790.00
Шуудан холбооны зардал	2,665,569.24
Бусдаар гүйцэтгүлсэн ажил	7,540,900.00
Сургалтын зардал	99,000.00
Хангамж материалын зардал	50,000.00
Банкны шимтгэлийн зардал	181,406.51
Засварын зардал	288,500.00
Элэгдэл, хорогдлын зардал	3,609,606.37
Түрээсийн зардал	17,003,045.00
Сонин сэтгүүл захиалгын зардал	71,200.00
Цэвэрлэгээ ариутгал, шинжилгээний зардал	60,000.00
Зээлийн хүүгийн зардал	667,924.27
Тээвэр, шатахууны зардал	390,106.00
Хүлээн авалтын зардал	3,334,146.00

ВИЗИОН АУДИТ

Зар суртчилгааны зардал	4,665,775.00
Бусад зардал	1,067,547.00
Хангамж оффисын зардал	1,472,614.00
Гишүүнчлэлийн төсөл	23,342,390.00
хэрэгжүүлсний зардал	24,397,945.00
Сургалтын зардал	
Ерөнхий ба Удирдлагын зардал	**178,982,052.52**

10. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

2021 оны 12-р сарын 31-наар бидэнд мэдэгдэж байгаа томоохон зарга, маргаан, нэхэмжлэл үгүй байна. Өөрөөр хэлбэл байгууллагын тасралтгүй үйл ажиллагаанд эргэлзээ төрөхүйц болзошгүй өр төлбөр байхгүй байна.

Гүйцэтгэсэн,

Аудитор Ц.Болдбаатар

Туслах аудитор Б.Дэлгэрмаа

Хүлээн зөвшөөрсөн:

03 сар 2022